

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2020 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
2021 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 20-НЫ ӨДӨР /ЛХАГВА ГАРАГ/-ИЙН
НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЬЁГ**

№	Баримтын агуулга	Хуудасны дугаар
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-26
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	27-92
	1.“Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийг товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	30-39
	2.“Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	39-47
	3.Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр 2020.08.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг , үргэлжилнэ/	47-71
	4.Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2018.03.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг , үргэлжилнэ/	71-73
	5.Музейн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2020.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг , үргэлжилнэ/	73-80
	6.Патентын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2020.12.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх /	80-84
	7.Үндэсний статистикийн хорооны даргыг томилох тухай асуудал	84-92

Хураангүй тэмдэглэл

Дөрөв.Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2018.03.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжилнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, мөн яамны Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч Ш.Мааяа, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны гүйцэтгэх захирал Х.Ганбаатар, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны ерөнхий нарийн бичгийн дарга Г.Адъяа, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын Ерөнхийлөгч О.Амартүвшин нар “Их хуралдай” танхимаас, Удирдлагын академийн багш, доктор, профессор Б.Уранцэцэг, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын Бодлого, судалгаа, хөгжлийн газрын дарга Ж.Оюунчимэг, Хуульч, судлаач Ц.Батнасан нар цахимаар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Төгсцэнгэл, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Батбаатар, мөн хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, референт Б.Мажигсүрэн нар байлцав.

Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх асуудлаар Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга Д.Ганбат дахин ажлын 3 өдрийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар завсарлага авав./16:50/

Дэлгэрэнгүй тэмдэглэл

Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг 3 хоногийн завсарлага авсан. Завсарлагын хугацаа дууссан тул Ардчилсан намын бүлгийн дарга Дашдондогийн Ганбат завсарлагатай холбоотойгоор завсарлагын хугацаа дууссан уу? Хэлэлцэж амжсан уу, ямар саналтай байна аа, саналаа хэлнэ үү?

Д.Ганбат: За үүний өмнө бас нэг асуудал байна аа. Монгол Улсын Үндсэн хуульд заасанчлан бид бүхэн бас нэг юман дээрээ анхаарахгүй бол болохгүй

байна аа. Өчигдөр оройны үйл явдлыг Монголчууд бүгдээрээ харлаа. Ээжээс төрөөгүй хүн байхгүй ээ. Гэтэл одоо дөнгөж төрсөн ээжид, нялх үрд нь Монгол Улсын Засгийн газар, энэ дарга, албан тушаалтнууд яаж хандаж байна гэдгийг нь бол бүгдээрээ харлаа.

Г.Занданшатар: Түрүүн ярьчихсан. Гишүүн ээ. Одоо энэ хөдөлмөрийн хуультай холбоотой

Д.Ганбат: За яах вэ, энэ ямар ч асуудлыг бид нар энэ чуулгандаа, энэ танхим дотроо ярих ёстой. Тийм учраас би нэг хэдхэн үг хэлчхээд, дараа нь хөдөлмөрийн хуультай холбоотой юмыг хэлчихье. Тэгэхгүй бол одоо энэ юм чинь хяналтаас гарч байна шүү. Үүнийг одоо удаа дараа Ардчилсан намын бүлэг анхааруулж байгаа. Тэгээд одоо тэр Үндсэн хуульд заасан эрхийнхээ дагуу Монголын ард түмний нэг хэсэг эзэн Чингисийнхээ талбай дээр гарч ирсэн, тайван жагсаал хийж байна аа. Үүнтэй бол одоо Ардчилсан намын бүлэг эв санаа нэг нэгдэлтэй байгаа гэдгээ илэрхийлсэн.

Тэгээд Монгол Улсын Ерөнхий сайд Ухнаагийн Хүрэлсүх танаа гээд Ардчилсан намын бүлэг шаардлага хүргүүлж байгаа юм аа. Монгол Улсын Үндсэн хуульд эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго хэмээн заасаар байтал коронавирусийн халдварт цар тахлын эсрэг Засгийн газар, улсын онцгой комиссоос өнгөрсөн нэг жилийн хугацаанд авч хэрэгжүүлж буй арга хэмжээ нь зохион байгуулалтгүй, иргэн, ард түмнээ өгсөн сэтгэлгүй хүмүүнлэг бус байна аа. Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг удаа дараа санал шаардлага хүргүүлж, Засгийн газар цар тахалтай тэмцэх бүх нийтийн хөл орооны үеэр хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, авч хэрэгжүүлж байгаа аа аливаа арга хэмжээнд хуулийн дагуу, хүмүүнлэг, үр дүнтэй байх ёстойг сануулсаар ирсэн ч эрхэлсэн ажилдаа

Г.Занданшатар: Та хөдөлмөрийн тухай хуулийн асуудал одоо завсарлагаа хэлэхгүй бол энэ завсарлагын хугацаа дууслаа. За 1 минут өгье, 1 минут. Тэр асуудлаа хэл. 1 минут.

Д.Ганбат: Монгол Улсын Ерөнхий сайдад ажилдаа хариуцлагагүй хандсан, Шадар сайд, мөн Эрүүл мэндийн сайд, Нийслэлийн онцгой комиссын дарга, хотын дарга энэ гуравтай хариуцлага тооцооч ээ гэдэг шаардлагыг хүргүүлсэн байгаа.

За ингээд хөдөлмөрийн хуулиар бол бид нар 3 хоногийн завсарлага авсан. Нэлээн нягталж үзлээ, ахиад сайн нягтлах шаардлагатай байна гэж үзээд ахиад 3 хоногийн завсарлага авч байна аа.

Г.Занданшатар: Ардчилсан намын бүлэгт хөдөлмөрийн хуулиар 3 хоногийн завсарлага өгч байна аа. Ардчилсан намын бүлэгт завсарлага өглөө.

Ер нь энэ хөдөлмөрийн хуулийн хэлэлцүүлгийг энэ лов форм цэг мн дээр тавьж энэ Ажил олгогч эздийн холбоо, Худалдаа аж үйлдвэрийн танхимын талаас ч тэр, Үйлдвэрчний эвлэлийн талаас ч гэсэн тэр санал зөрөлдөөнтэй олон асуудал байгаа учраас энэ маргаантай асуудлыг сайтар хэлэлцэж, нэг мөр болгож эвсэл зөвшилцөлд хүрч байж энэ хөдөлмөрийн хууль батлагдана аа.

Энэ бол иргэний хуулийн дараа орж байгаа хөдөлмөрийн гэрээний зохицуулалтын хууль. Иргэний хуультайгаа ч уялдах ёстой. Тийм учраас бусад хууль тогтоомжуудтай уялдуулан боловсруулж, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт үзэл санаатай нийцүүлж, зах зээлийн зарчим, иргэний хуулийн суурь зарчим, өмчлөх эрх өмчлөлийн удирдлагын эрхийн зарчмуудтай уялдуулж одоо бас

гүйцээн боловсруулах шаардлагатай. Саналуудаа бас нарийвчлан гаргах шаардлагатай. Тэгэхдээ энэ хууль бол Ганбат дарга аа, 1999 оноос хойш ихээхэн дэвшил авчирч байгаа. Одоо энэ ковидын үед зайнаас ажиллахаас авахуулаад тэр жасаагаар ажиллах олон асуудлууд их дэвшил гарч байгаа хууль учраас бас алгуурлаж болохгүй. Тэгэхдээ асуудлууд дотор нь байгаа энэ хөдөлмөрийн харилцаа бол маш нарийн харилцааны асуудал учраас аль алиныг нь олон хүнийг хамарсан, одоо Монголын бараг хувийн сектор болон төрийн сектор, ажил хийж байгаа бүх хүнд хамаарч байгаа асуудал учраас сайн судалж боловсруулах хэрэгтэй шүү. За ингээд завсарлага өглөө.

Дараагийн асуудалд орно.